

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2023/38/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2023 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: Ц.Хосжаргал

Утас: 260512 Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)

Аудитор: С.Отгонхорлоо

Утас: 261628 Цахим хаяг: [otgonkhorloos@audit.gov.mn](mailto:otgonkhorloos@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал : С.Тунгалаг

Утас: 70001778 Цахим хаяг: [info@imkaudit.mn](mailto:info@imkaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>10</b>
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	12
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>13</b>
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>15</b>
5.1 Төлбөрийн акт .....	15
5.2 Зөвлөмж.....	15
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>17</b>
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТХЗТ	Төрийн хүндэт зочны танхим
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗҮҮЗТ	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

### ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.ЦЭНГҮҮНЖАВ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 150 дугаар тогтоолын дагуу тайланд онд Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-д Иргэний нисэхийн ерөнхий газраас 1,350.0 сая төгрөгийг санхүүжилт олгохоор баталсан ч санхүүжилт олгогдоогүй байна.

#### Аудитын гол асуудал

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 12 сарын 12-ны өдрийн ХЭХТ22/03 дугаар тогтоолоор Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн баталж, тайлант. оны нийт орлогыг 709.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,218.6 сая төгрөгөөр, 509.6 сая төгрөгийн алдагдалтай баталснаас, гүйцэтгэлээр 718.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийт зардал 1,056.7 сая төгрөгт хүрч, 324.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын хувьцаа эзэмшигчтэй байгуулсан 2022 оны онцгой үүрэг бүхий гэрээнд тусгагдсан 24 үүргийн биелэлтийг 100.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

#### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	<b>683,643,234.32</b>	<b>416,151,457.13</b>
1.1.2	Дансны авлага	1,770,000.00	2,456,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	12,157,432.43	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	<b>43,670,306.39</b>	<b>53,193,523.74</b>
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	30,313,572.70	24,769,734.00
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>771,554,545.84</b>	<b>496,570,714.87</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	619,414,847.05	537,339,817.10
1.2.2	Биет бус хөрөнгө	10,903,819.12	9,750,819.07
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	48,407,494,354.07	48,407,494,354.08
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>49,037,813,020.24</b>	<b>48,954,584,990.24</b>
1.3	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>49,809,367,566.08</b>	<b>49,451,155,705.11</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	3,591,141.77	1,163,891.12
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	38,401,993.57	3,074,594.36
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	150,000.00	3,700,000.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>42,143,135.34</b>	<b>7,938,485.48</b>
2.1.2	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>42,143,135.34</b>	<b>7,938,485.48</b>
	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.3	<b>Өмч</b>	49,373,854,300.00	49,373,854,300.00
2.3.1	-төрийн	49,373,854,300.00	49,373,854,300.00
2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	<b>393,370,130.74</b>	<b>69,362,919.63</b>
2.3.10		-	-
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>49,767,224,430.74</b>	<b>49,443,217,219.63</b>
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>49,809,367,566.08</b>	<b>49,451,155,705.11</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	221,337,245.53	708,941,273.26
2	Борлуулалтын өртөг	-	-
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	221,337,245.53	708,941,273.26
5	Хүүний орлого	21,001,746.15	8,520,930.10
8	Бусад орлого	949,751,584.34	1,394,181.48
9	Борлуулалт, маркетингийн зардал	183,711,605.49	403,360,524.68
10	Ерөнхий ба удирдлагын зардал	606,509,844.62	653,339,524.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(17,502.07)	14,688,543.59
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	401,851,623.84	(323,155,120.25)
19	Орлогын татварын зардал	40,502,156.78	852,090.86
20	<b>Татварын дараахь ашиг (алдагдал)</b>	<b>361,349,467.06</b>	(324,007,211.11)
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	361,349,467.06	(324,007,211.11)
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
24	<b>Орлогын нийт дүн</b>	361,349,467.06	(324,007,211.11)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	<b>2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>1,000,000.00</b>	<b>48,729,038,901.60</b>	<b>708,974,202.08</b>	<b>49,439,013,103.68</b>
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,000,000.00</b>	<b>48,729,038,901.60</b>	<b>708,974,202.08</b>	<b>49,439,013,103.68</b>
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	361,349,467.06	361,349,467.06
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	49,372,854,300.00	(48,729,038,901.60)	(643,815,398.40)	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	33,138,140.00	33,138,140.00
8	<b>2021 оны 01-р сарын 01-ны үлдэгдэл</b>	<b>49,373,854,300.00</b>	<b>-</b>	<b>393,370,130.74</b>	<b>49,767,224,430.74</b>
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>49,373,854,300.00</b>	<b>-</b>	<b>393,370,130.74</b>	<b>49,767,224,430.74</b>
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(324,007,211.11)	(324,007,211.11)
8	<b>2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>49,373,854,300.00</b>	<b>-</b>	<b>69,362,919.63</b>	<b>49,443,217,219.63</b>



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	1,192,744,040.00	791,515,500.46
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>		
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	229,565,970.00	790,600,382.99
1.1.6	Бусад мөнгөн орлого	963,178,070.00	915,117.47
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	804,881,428.64	1,076,581,569.51
1.2.1	Ажиллагчдад төлсөн	356,128,513.95	504,654,263.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	104,291,557.22	143,838,175.52
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	102,606,879.92	104,407,808.79
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	115,895,914.55	127,281,949.90
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,685,813.27	28,643,920.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	48,653,643.59	127,615,060.38
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	4,552,746.00	3,819,210.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	62,066,360.14	36,321,181.92
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>387,862,611.36</b>	<b>(285,066,069.05)</b>
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
2.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	21,001,746.15	8,520,930.10
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	21,001,746.15	8,520,930.10
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8		-	-
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>365,175,353.74</b>	<b>5,635,181.83</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	354,965,353.74	5,635,181.83
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,210.00	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(344,173,607.59)</b>	<b>2,885,748.27</b>
3	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
3.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	33,138,140.00	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	33,138,140.00	-
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(33,138,140.00)</b>	-
4	Валютын ханшийн зөрүү	(17,502.07)	14,688,543.59
4.1	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>10,533,361.70</b>	<b>(267,491,777.19)</b>
5	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	673,109,872.62	683,643,234.32
6	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	683,643,234.32	416,151,457.13

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	-	-	-	-	-
	а/ Гол нэр төрлөөр	-	-	-	-	-
	б/ Үнийн дүнгээр	-	-	-	-	-
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	<b>1,192,090.6</b>	<b>709,000.0</b>	<b>718,856.4</b>	<b>(9,856.4)</b>	<b>101.4</b>
Үүнээс	а/ Засгийн газрын санхүүжилт	949,262.8	-	-	-	-
	в/ Хүүгийн болон бусад орлого	21,490.6	9,000.0	9,915.1	(915.1)	110.2
	б/ Хүндэт зочны танхимын орлого	221,337.2	700,000.0	708,941.3	(8,941.3)	101.3
	г/ Ханшийн зөрүүний олз	-	-	14,688.5	(14,688.5)	-
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	<b>790,221.5</b>	<b>1,218,590.3</b>	<b>1,056,700.9</b>	<b>161,889.4</b>	<b>86.7</b>
	Үүнээс удирдлагын зардал	540,187.1	704,174.6	564,466.4	139,708.2	80.2
4	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	401,869.1	(509,590.3)	(326,156.0)	(183,434.3)	64.0
5	Цэвэр ашиг /алдагдал/	401,869.1	(509,590.3)	(324,008.0)	(185,582.3)	63.6
<b>6</b>	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>193,371.3</b>	<b>260,892.2</b>	<b>232,781.1</b>	<b>28,111.1</b>	<b>89.2</b>
	а/ Орлогын татвар	40,502.1	1,000.0	852.0	148.0	85.2
	б/ НӨАТ	11,718.7	39,425.7	36,453.8	2,971.9	92.5
	в/ НДШ	104,291.6	160,370.2	143,838.2	16,532.0	89.7
	г/ Хүн амын орлогын татвар	36,630.7	59,440.9	50,687.8	8,753.1	85.3
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	-	-	-	-	-
	е/ Гаалийн татвар	-	-	-	-	-
	ё/ Тээврийн хэрэгслийн татвар	228.2	453.1	395.7	57.4	87.3
	ж/ Бусад	-	562.3	553.6	8.7	98.5
<b>7</b>	<b>Төрийн өмчийн ногдол ашиг</b>	<b>36,135.0</b>	-	-	-	-
<b>8</b>	<b>Нийт ажиллагсдын тоо</b>	<b>27</b>	<b>41</b>	<b>28</b>	<b>13</b>	<b>68.3</b>
9	Нийт цалингийн сан	441,938.0	668,209.2	621,054.0	47,155.2	92.9
10	Нэг ажилтны дундаж цалин	1,416.5	1,358.1	2,016.4	(658.3)	148.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.7	1.7	1.5	0.2	88.2
12	Хөрөнгө оруулалт	399,664.9	22,350.0	5,635.2	16,714.8	25.2
<b>13</b>	<b>Нийт авлага</b>	<b>13,297.0</b>	<b>5,000.0</b>	<b>2,456.0</b>	<b>2,544.0</b>	<b>49.1</b>
	Үүнээс: найдваргүй	-	-	-	-	-
	Нийт өглөг	42,143.1	5,400.0	7,938.5	(2,538.5)	147.0
14	Богино хугацаат өр төлбөр	42,143.1	5,400.0	7,938.5	(2,538.5)	147.0

Урт хугацаат өр төлбөр	-	-	-	-	-
------------------------	---	---	---	---	---

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

"Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-ийн зорилго нь дэлхийд тэргүүлэгч нисэх буудлын менежменттэй үндэсний компани болоход оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг шинэ нисэх буудлын менежмент хэрэгжүүлэх хамтарсан компанийн 49 хувийг эзэмших, хяналтыг хэрэгжүүлэн ажиллах ба нисэх буудлаар үйлчлүүлэгчдэд олон улсын стандарт, шаардлагын түвшинд хүрсэн, аюулгүй байдлыг хангасан, тав тухтай нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, нисэх буудлын хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх замаар Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, ашигтай ажиллагааг хангуулах гэж тодорхойлжээ.

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн өмчийн 66 хувийг Зам тээврийн хөгжлийн яам, 34 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж байна.

Тус компани үйл ажиллагаандаа салбарын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөж байна.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлыг 1 ээлжит бус хурлыг 2 удаа тус тус зохион байгуулж, 5 тогтоол гарч хэрэгжилт 100 хувьтай байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн "Компанийн бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" 2021 оны ХЭХТ21/05 дугаар тогтоолоор Дотоод аудиторын орон тоог баталсан боловч ажилтныг томилоогүй байна.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж танилцсан болно.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 358,211.8 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	683,643.2	416,151.5	(267,491.7)
Авлага	1,770.0	2,456.0	686.0
Татвар, НДШ – ийн авлага	12,157.4	-	(12,157.4)
Урьдчилж төлсөн тооцоо	30,313.5	24,769.7	(5,543.8)
Бараа материал	43,670.3	53,193.5	9,523.2
Үндсэн хөрөнгө	49,037,813.1	48,954,585.0	(83,228.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>49,809,367.5</b>	<b>49,451,155.7</b>	<b>(358,211.8)</b>
Өр төлбөр	42,143.1	7,938.5	(34,204.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	49,767,224.4	49,443,217.2	(324,007.2)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>49,809,367.5</b>	<b>49,451,155.7</b>	<b>(358,211.8)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 416.2 сая төгрөгт хүрч буурсан нь компанийн 2022 онд авахаар төлөвлөсөн Засгийн газрын санхүүжилт буюу ИНЕГ-ын давсан орлогоос санхүүжигдээгүй эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны эхний үлдэгдлээс 2021 оны худалдан авалтын 12.1 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг тайлант оны НӨАТ-ын өглөгт суутган тооцсон, ТХЗТ-ын танхимын орлогын 2.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Тайлант онд 2023 онд тооцогдох 3 автомашины даатгалын төлбөр 2.0 сая, 2 машины гаражийн түрээс 4.6 сая, шатахууны үлдэгдэл 0.7 сая, Юнивишн ХХК-д интернэтийн 1 сарын барьцаа төлбөр 0.3 сая, байрны түрээс 5.8 сая, аудитын төлбөрт 11.0 сая, МИАТ ХХК-ийн билетийн төлбөр 0.3 сая төгрөгийг урьдчилж төлсөн тооцоо дансанд авлага бүртгэлтэй байна.

Бараа материал худалдан авсан 67.5 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 58.0 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 53.2 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 21.8 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу худалдаж авсан 5.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 87.7 сая төгрөгийн байгуулсан элэгдлийн дүнгээр буурсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 38.4 сая төгрөгийн ААНОАТ, 3.6 сая төгрөгийн цалингийн өглөгийг бүрэн барагдуулжээ. Тайлант оны эцэст татварын 3.0 сая төгрөгийн өглөг, урьдчилж орсон орлого 3.7 сая төгрөг, цалингийн 1.2 сая төгрөгийн өглөгтэй байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 324.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны алдагдалтай ажилласнаас буурсан үзүүлэлттэй байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны ХЭХТ21/07 дугаар тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 709.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,218.6 сая төгрөгөөр, 509.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 22.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Нийт орлогын гүйцэтгэл 718.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 9.9 сая буюу 1.4 хувиар давж биелсэн нь Хүндэт зочны танхимын орлогын бүрдүүлэлт нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,056.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 161.9 сая төгрөгөөр дутуу буюу 86.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 9 төсөл, арга хэмжээнд 5.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант оны алдагдал 324.0 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 186.4 сая төгрөгөөр алдагдлыг бууруулжээ.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,056.7 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 10.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь хөрөнгө оруулалтын зардлыг 16.7 сая төгрөгөөр бууруулж шинэчлэн баталж хэмнэлт үүсгэсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих орлогын 41.9 сая мянган төгрөгийн 6, зарлагын 110,767.5 мянган төгрөгийн 11, нийт 152.7 сая төгрөгийн 17 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар нийт 58.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 58.0 сая төгрөгийг залруулсан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар тогтоосон 1.3 сая төгрөгийн 1 акт, хүргүүлсэн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 4 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд биелэлт 85.7 хувьтай байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,269.9	1	1,269.9	100.0
Албан шаардлага	2	-	2	-	100.0
Зөвлөмж	4	493.7	3	-	75.0
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>1,763.6</b>	<b>6</b>	<b>1,269.9</b>	<b>85.7</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн үйл ажиллагааны зардлыг Иргэний нисэхийн ерөнхий газраас батлагдсан төсөвтөө зохицуулалт хийх замаар санхүүжүүлж ирсэн ба тус байгууллагын орлого буурсантай холбоотойгоор цаашид санхүүжүүлэх боломжгүй талаар мэдэгдсэн байна. Иймд хувьцаа эзэмшигчдийн хурлаар зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх талаар эрх бүхий дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.4 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд 0.3 сая төгрөгийг бэлэг дурсгалын зардалд зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Төлбөрийн баримттай холбоотой асуудал.

##### 1.1 Илрүүлэлт:

Бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 1.0 сая төгрөгөөр илүү байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2 Өгсөн зөвлөмж:

Дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, төлбөрийн баримтын системийг тогтмол хянаж байх зөвлөмж өгөв.

#### Санхүүгийн программтай холбоотой асуудал

##### 2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн программ нь ерөнхий журналаас дэлгэрэнгүй бүртгэлд хөрвүүлэхдээ дутуу татагдаж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх" Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 47 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3.4 дүгээр заалтыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 2.2 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн программ хангамж нийлүүлэгч байгууллагад хандах, холбогдох журам зааварт нийцүүлэн хөгжүүлэлт хийлгэх.

#### Өр төлбөртэй холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



3.1 Илрүүлэлт:

Он дамжсан байгууллагад төлөх 1.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 үгээр зүйл 8/-д " Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасныг заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Он дамжсан өглөгийг барагдуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 1,007.1 мянган төгрөгөөр илүү байна.	1	1,007.1					1	1,007.1				
Санхүүгийн программ нь ерөнхий журналаас дэлгэрэнгүй бүртгэлд хөрвүүлэхдээ дутуу татагдаж байна.	1	-					1	-				
Он дамжсан байгууллагад төлөх 1,163.9 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна.	1	1,163.9					1	1,163.9				
Тайлант онд 253.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зардалд зарцуулсан.	1	253.0	1	253.0								
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>2,424.0</b>	<b>1</b>	<b>253.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>2,171.0</b>				